

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/77/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

(Хотын нэр оруулах)

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734

Аудитын менежер:

Утас: 7052-3020

Аудитор:

Утас: 99031981

Цахим хаяг: [dornogovi@audit.mn](mailto:dornogovi@audit.mn)

Ц.Лүндэгмаа

Цахим хаяг: .....

М.Бямбадорж

Цахим хаяг: [mnbaudithhk@gmail.com](mailto:mnbaudithhk@gmail.com)

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

**АГУУЛГА**

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил .....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3	Менежментийн захидал .....	11
3.1	(Аудитын чиглэл) .....	
3.1.1	Илрүүлэлт: .....	
3.1.2	Эрсдэл:.....	
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	
3.2	(Аудитын чиглэл) .....	
3.2.1	Илрүүлэлт: .....	
3.2.2	Эрсдэл:.....	
3.2.3	Өгсөн зөвлөмж:.....	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	

## 1 Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар бүг, Уран нутгийн өмчийн III бүлэг,  
Утас: (705) 2-27-34

2019.03.04 № 1-6/2019  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД  
СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Х.ХОРОЛСҮРЭН ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Сайншанд сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Аудитын гол асуудал:**

- Тайлант жилд батлагдсан бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлын 21700,0 мянган төгрөгийг зарцуулахдаа шууд худалдан авалт хийсэн байна. Шууд худалдан авсан ажил гүйлгээний 43 хувийг ИТХ-ийн гишүүдийн үйл ажиллагааг сурталчилахад чиглэгдсэн зардалд, хурлын хоолны зардалд 25 хувь буюу 5208,6 мянган төгрөгийг, дэмжлэг шагналд 26 хувь буюу 5403,0 мянган төгрөгийг тус тус зарцуулагдсан байна. Энэ нь ТБОНӨХБАУХАТ хууль болон Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" журмыг тус тус зөрчсөн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль 41,6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8.-д "Тухайн байгууллага журмын 7.5-д заасан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад урсгал зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд төсвийн захирагчийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт, товчоо, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт, өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга, хөрөнгийн зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн дансны хуулга болон бусад бичиг баримт хамаарна. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна" заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын дарга Х.ХОРОЛСҮРЭН-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 12-оос 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймгийн төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Мөнгө Нөөц Баялаг аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын ИТХурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг аудит” ХХК -д 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Сайншанд сумын ИТХурал нь Иргэддээ тулгуурласан чадвартай, хариуцлагатай Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлж, хөгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн ИТХ-аас Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Аймгийн ИТХ-ын тогтоол

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурлын даргын 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 10 тоот захирамжаар Бодлогын баримт бичиг, журам батлах тухай захирамж гарсан байна. Уг баримт бичгийн эрх зүйн үндэслэл хэсэгт УСНББОУС-ыг тусгаагүй мөн Сангийн сайдын 388 тоот тушаалаар батлагдсан дансны зааврыг өөрийн онцлогт тохируулан тусгах шаардлагатай байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайншанд сумын ИТХурал санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатан дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 1 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал-ын хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд нийт зардлыг суурь болгон болгон авсантай холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал 2018 оны 93770 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 937,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь зардлын 1 хувиас бага эрсдэл нь санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	21,700.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	21,700.00	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

- НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгож мөрдөх

### 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 89654,5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 87695,4 мянган төгрөг буюу 97,8 хувьтай байгаа нь 1959,1 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарч татан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Сайншанд сумын ИТХурал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 67 хувьтай байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурлын даргын 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 10 тоот захирамжаар Бодлогын баримт бичиг, журам батлах тухай захирамж гарсан байна. Уг баримт бичгийн эрх зүйн үндэслэл хэсэгт УСНББОУС-ыг тусгаагүй мөн Сангийн сайдын 388 тоот тушаалаар батлагдсан дансны зааврыг өөрийн онцлогт тохируулан тусгах шаардлагатай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурал 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХурлын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Худалдан авалт, гэрээний биелэлт

**Илрүүлэлт**

Тайлант жилд батлагдсан бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлын 21700,0 мянган төгрөгийг зарцуулахдаа шууд худалдан авалт хийсэн байна. Шууд худалдан авсан ажил гүйлгээний 43 хувийг ИТХ-ийн гишүүдийн үйл ажиллагааг сурталчлахад чиглэгдсэн зардалд, хурлын хоолны зардалд 25 хувь буюу 5208,6 мянган төгрөгийг, дэмжлэг шагналд 26 хувь буюу 5403,0 мянган төгрөгийг тус тус зарцуулагдсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хууль болон Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" журмыг тус тус зөрчсөн байна."

**Эрсдэл**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт сулрах, бэлтгэн нийлүүлэгч нарт ижил тэгш хандах хандлага суларна.

**Зөвлөмж**

Энэ нь үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ТБӨХБАҮХАТХ болон Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" тус тус зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

**Хариуцах ажилтан**

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХ-н Дарга Х.Хоролсүрэн, нягтлан бодогч Ц.Адъяа

**Төсвийн захирагчийн хариу**

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

**Илрүүлэлт**

Тухайн байгууллагын санхүүгийн тайланд өгүүлбэрчилсэн хэлбэрээр тайлант жилд хийгдсэн онцлог үйл явдал, санхүүгийн ажил гүйлгээнүүдийн өмнөх онтой жишсэн мэдээлэл, шинэчилсэн хууль эрх зүйн шийдвэр, үндсэн үйл ажиллагааны зорилго зорилт хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл байхгүй байна.

**Зөвлөмж**

Тухайн байгууллагын зорилго зорилт түүний хүрсэн төвшин, санхүүгийн жилийн төсөв түүний зарцуулалтын талаар мэдээлэл бэлтгэж байх нь мэдээлэл хэрэглэгч нар шуурхай мэдээлэл авах боломж бүрдэх, санхүүгийн тайлан ойлгомжтой байх боломж бүрдэнэ.

**Хариуцах ажилтан**

Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХ-н Дарга Х.Хоролсүрэн, нягтлан бодогч Ц.Адъяа

**Эрсдэл**

2. Тухайн байгууллагын тайлант оны санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлангуудаас хэрэглэгчид шуурхай мэдээлэл авах боломж алдагдана.

**Төсвийн захирагчийн хариу**

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

##### **ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ч.АРИУНАА	Огноо:
АУДИТЫН МЕНЕЖЕР	Ц.ЛҮНДЭГМАА	Огноо:

##### **БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР	М.БЯМБАДОРЖ	Огноо:
---------	-------------	--------

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТАЛСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,468,526.00</u></b>	<b><u>3,358,424.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	90,000.00	210,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	81,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	9,000.00	210,000.00
3351	Байгууллагаас авах авлага	9,000.00	210,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	3,378,526.00	3,148,424.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	3,378,526.00	3,148,424.00
35410	Бичиг хэргийн материал	360,500.00	472,498.00
35420	Аж ахуйн материал	2,213,426.00	2,675,926.00
35430	Сэлбэг хэрэгсэл	804,600.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>11,901,200.33</u></b>	<b><u>8,022,035.43</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	11,901,200.33	8,022,035.43
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	11,901,200.33	8,022,035.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,820,000.00	98,430,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,909,166.61)	(96,001,166.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,488,011.00	10,083,011.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,412,481.96)	(7,246,514.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,891,231.50	20,294,231.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,026,393.60)	(17,587,526.04)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>15,369,726.33</u></b>	<b><u>11,380,459.43</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>78,777.00</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	78,777.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	78,777.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>15,290,949.33</u></b>	<b><u>11,380,459.43</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	15,290,949.33	11,380,459.43
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,434,343.54	(476,146.36)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,910,489.90)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>15,369,726.33</u></b>	<b><u>11,380,459.43</u></b>

Сайншанд сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>73,303,290.85</b>	<b>89,864,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,978,177.25</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,978,177.25	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,978,177.25	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,978,177.25	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>69,325,113.60</b>	<b>89,864,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	210,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	210,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	69,325,113.60	89,654,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,325,113.60	89,654,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>72,792,004.84</b>	<b>93,774,989.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>71,982,004.84</b>	<b>91,815,871.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	71,982,004.84	91,815,871.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	44,037,639.90	49,894,683.00
210101	Үндсэн цалин	44,037,639.90	49,894,683.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,879,819.20	5,779,870.00
210201	Тэтгэврийн даатгал	3,164,848.20	4,560,423.00
210202	Тэтгэмжийн даатгал	348,352.00	273,101.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	435,435.00	301,363.00
210204	Ажилгүйдлийн даатгал	87,088.00	141,058.00
210205	Эрүүл мэндийн даатгал	844,096.00	503,925.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,715,466.50	4,178,526.00
210401	Бичиг хэрэг	4,127,309.10	1,163,633.00
210402	Тээвэр, шатахуун	1,771,340.90	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	348,552.50	486,314.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	963,115.00	528,579.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	505,149.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	975,000.00	1,254,600.00
210604	Урсгал засвар	975,000.00	1,254,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	213,000.00	236,900.00
210702	Дотоод албан томилолт	213,000.00	236,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,418,350.00	22,286,128.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,327,850.00	22,082,028.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,500.00	95,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	20,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,742,729.24	8,185,164.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,524,097.00	2,308,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,218,632.24	5,877,164.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	810,000.00	1,959,118.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	810,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	810,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	1,959,118.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,959,118.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>511,286.01</b>	<b>-3,910,489.90</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>511,286.01</b>	<b>-3,910,489.90</b>

Сайншанд сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>69,325,113.60</b>	<b>89,864,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>69,325,113.60</b>	<b>89,864,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	210,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	210,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	69,325,113.60	89,654,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,325,113.60	89,654,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>68,225,113.60</b>	<b>87,866,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>68,225,113.60</b>	<b>87,866,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>67,325,113.60</b>	<b>85,697,382.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	43,949,639.90	49,894,683.00
210101	Үндсэн цалин	43,949,639.90	49,894,683.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,801,042.20	5,768,647.00
210201	Тэтгэврийн даатгал	3,055,209.00	3,711,547.00
210202	Тэтгэмжийн даатгал	349,168.00	514,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	436,455.00	411,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	87,294.00	102,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	872,916.20	1,028,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,392,548.50	4,427,024.00
210401	Бичиг хэрэг	1,048,603.00	1,315,031.00
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	348,552.50	486,314.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	295,393.00	625,679.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,392,934.00	502,000.00
210604	Урсгал засвар	1,392,934.00	502,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	213,000.00	236,900.00
210702	Дотоод албан томилолт	213,000.00	236,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,376,220.00	21,668,128.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,285,720.00	21,464,028.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,500.00	95,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,199,729.00	3,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,199,729.00	3,200,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>900,000.00</b>	<b>2,169,118.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	900,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	2,169,118.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,169,118.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,998,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,998,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,998,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,100,000.00	1,998,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,100,000.00	1,998,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-1,100,000.00</b>	<b>-1,998,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00	00.00

Сайншанд сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.4 АУДИТАЛСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	11,768,306.99	190,285.25	2,821,071.08	14,779,663.32
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	101,986.45	101,986.45
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>11,768,306.99</b>	<b>190,285.25</b>	<b>2,923,057.53</b>	14,881,649.77
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(101,986.45)	-	(101,986.45)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	511,286.01	511,286.01
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>11,768,306.99</b>	<b>88,298.80</b>	<b>3,434,343.54</b>	15,290,949.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>11,768,306.99</b>	<b>88,298.80</b>	<b>3,434,343.54</b>	15,290,949.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,910,489.90)	(3,910,489.90)
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>11,768,306.99</b>	<b>88,298.80</b>	<b>(476,146.36)</b>	11,380,459.43

4.5 АУДИТАЛСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	90,413,700.00	87,695,382.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	90,413,700.00	87,695,382.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	90,413,700.00	87,695,382.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	51,428,700.00	49,894,683.00
210101	Үндсэн цалин	51,428,700.00	49,894,683.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,171,400.00	5,768,647.00
210201	Тэтгэврийн даатгал	4,114,300.00	3,711,547.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,428,600.00	4,427,024.00
210401	Бичиг хэрэг	1,188,600.00	1,315,031.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540,000.00	486,314.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	625,679.00
210602	Тавилга	595,000.00	1,998,000.00
210604	Урсгал засвар	1,905,000.00	502,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	750,000.00	236,900.00
210702	Дотоод албан томилолт	750,000.00	236,900.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,935,000.00	21,668,128.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,700,000.00	21,464,028.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,000.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,000.00	95,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	90,413,700.00	89,654,500.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	90,413,700.00	89,654,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	90,413,700.00	89,654,500.00